



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/188

Улаанбаатар хот

Г

### Чиглэл батлах тухай

Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.2.2.1, 2.2.2.3 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Төрөлжсөн ахлах сургуулийн талаар баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан доор дурдсан арга хэмжээ авч тухай бүр танилцуулахыг холбогдох албан тушаалтанд үүрэг болгосугай.

2.1. хавсралтаар баталсан чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор батлуулж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т;

2.2. төрөлжсөн ахлах сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөө боловсруулж, 2025 оны 06 дугаар сард багтаан батлуулах, түүнд хүчин төгөлдөр мөрдеж байгаа бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг нийцүүлэх, төрөлжих чиглэл бүрээр хэрэгжүүлэх удирдамж боловсруулах арга хэмжээ авч ажиллахыг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (Л.Лхагвасүрэн)-д;

2.3. мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын холбогдох дүрэм, журамд нэмэлт, өөрчлөлт оруулж 2025 оны 06 дугаар сард багтаан батлуулахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын газар (Ү.Өлзийцэцэг)-т;

2.4. мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын мэргэжлийн чиглэл/хөтөлбөрийг нарийвчлан тогтоох, сургалтын жишиг хөтөлбөр, хэрэгжүүлэх арга зүйн удирдамж боловсруулах, сургалт зохион байгуулах багшлах хүний нөөцийг давтан бэлтгэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын газар (Ү.Өлзийцэцэг), Ерөнхий боловсролын газар (М.Цогзолмаа) нарт;

2.5. төрөлжсөн ахлах сургуулийн бүтцээр 2025-2026, 2026-2027, 2027-2028 оны хичээлийн жилээс сургалтын үйл ажиллагаа эрхлэх аймаг, дүүрэг, ерөнхий боловсролын сургуулийн нэр, төрөлжих чиглэлийг харьяа нутаг дэвсгэрийн Засаг

14261 0564

даргатай зөвшилцөн 2025 оны 05 дугаар сард багтаан баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэхийг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.6.төрөлжсөн ахлах сургуулийн бүтцээр 2025-2026 оны хичээлийн жилээс ажиллах сургуулийн бэлэн байдлыг хангаж, сургалтын үйл ажиллагаа эхлүүлэхийг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга нарт;

2.7.төрөлжсөн ахлах сургуулийн суралцагчдад мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт зохион байгуулахад шаардагдах сурах бичиг, ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүний болон мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирал нарт;

2.8.төрөлжсөн ахлах сургуульд их сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд хамтран ажиллахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагад;

2.9.төрөлжсөн ахлах сургуулийг санхүүжүүлэх санхүүжилтийн саналыг 2025 оны 06 дугаар сард багтаан танилцуулах, лаборатори, дадлагын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т;

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Х.Батжаргал)-д даалгасугай.



Боловсролын сайдын 2045 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн 11/188 дугаар тушаалын хавсралт

## ТӨРӨЛЖСӨН АХЛАХ СУРГУУЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

12937 9116621 9024070582

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт заасан "Ахлах сургуулийг бие даасан хэлбэрээр төрөлжүүлэн хөгжүүлэх", "Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжaa олгож, мэргэжлийн эрх олгох, сонгох боломжтой төрөлжсөн ахлах сургууль байгуулах" зорилтыг хэрэгжүүлэхэд энэ чиглэлийг баримтална.

1.2. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлтэй уялдуулан ахлах сургуулийг<sup>1</sup> төрөлжүүлэн хөгжүүлж, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвартай, мэргэжлийн эрхтэй хүний нөөц бэлтгэх нь төрөлжсөн ахлах сургуулийн тэргүүлэх чиглэл байна.

1.3. Ахлах сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд суралцагч бүрийн сонирхол, авьяас чадвар, ялгаатай байдлыг хүндэтгэх, тодорхой чиглэлээр сургалтын хөтөлбөрөө сонгон судлах боломж олгох, бие даан суралцах болон бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ирээдүйд эзэмших ажил мэргэжлийн дагуу суурь ур чадвар эзэмшүүлэхэд төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилах зарчим баримтална.

1.4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.5-д заасан чиглэлээр дунд ангиас төрөлжсөн сургалт зохион байгуулж байгаа ерөнхий боловсролын сургууль болон ердийн ахлах сургуульд энэ чиглэл хамаарахгүй.

### Хоёр. Ахлах сургуулийн бүтэц, чиг үүрэг, төрөлжих чиглэл

2.1. Ахлах сургууль нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 20.2.4-т заасны дагуу 10-12 дугаар ангитай байна.

2.2. Энэ чиглэлийн 2.4-т заасан чиглэлээр төрөлжих ахлах сургууль нь суралцагчдад бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхийн зэрэгцээ тэднийг дараагийн түвшний боловсрол болон ажил мэргэжлээ сонгоход бэлтгэх, мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах, хувь хүний хөгжлийг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.3. Ахлах сургууль нь суралцагчдын насны онцлог, суралцагчдын хөтөлбөрөөр хичээлээ сонгон судлах болон мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтад хамрагдах боломжийг суралцагчдад олгож, тэдний ажил мэргэжлийн замнал (карьер)-ыг төлөвлөхөд нь дэмжлэг үзүүлнэ.

2.4. Ахлах сургууль нь технологи, хөдөө аж ахуй, эрүүл мэнд-сувилахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, байгалийн ухаан, математик, нийгэм-хүмүүнлэг, соёл урлаг, спортын чиглэлээр төрөлжинө.

<sup>1</sup> Ахлах сургуулийг урт хугацаанд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын 2.2-т заасан аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн 91 төвд, дунд хугацаа (2025-2028 онд)-нд аймаг, нийслэлийн дүүрэг бүрд ахлах сургуулийг үе шаттайгаар хөгжүүлнэ.

2.4.1.Төрөлжих чиглэл нь суралцагчдын цаашид суралцах боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн ур чадвар эзэмших, хөдөлмөрийн зах зээлд шилжих бэлтгэл болно.

2.4.2.Төрөлжих чиглэлийг бус нутгийн хөгжил, эдийн засгийн тэргүүлэх чиглэл, аж ахуйн нэгж, түнш байгууллагатай хамтран ажиллах боломж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, суралцах хэрэгцээ, ажил мэргэжлийн сонголт, багшах хүний нөөцийн бэлэн байдал, сургалтын орчин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хүртээмж зэргийг харгалzan аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.

2.5.Төрөлжсөн ахлах сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан багш мэргэжлийн сонгон бүлгийг холбогдох журмын дагуу зохион байгуулж болно.

### **Гурав. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр**

3.1.Төрөлжсөн ахлах сургуульд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө ерөнхий боловсролын заавал судлах, ажил мэргэжлийн чиг баримжаанд үндэслэсэн сонгон судлах, мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт болон хичээлийн дараах үйл ажиллагаа гэсэн үндсэн хэсгээс бүрдэнэ:

3.1.1.заавал судлах хичээл: монгол хэл, бичиг, уран зохиол, гадаад хэл, математик, байгалийн ухаан, монголын түүх, нийгмийн ухаан, мэдээллийн технологи, программчлал;

3.1.2.сонгон судлах хичээл: энэ чиглэлийн 2.4-т заасан төрөлжсөн чиглэлээр, суралцагчдын ажил мэргэжлийн сонголтод үндэслэн судлах хичээл;

3.1.3.хичээлийн дараах үйл ажиллагаа: биеийн тамир, спортоор хичээллэх, ажил мэргэжлийн чиг баримжaa олгох, сайн дурын үйл ажиллагаанд оролцох зэрэг үйл ажиллагааг заавал хэрэгжүүлэх.

3.2.Сургалтын төлөвлөгөөн дэх заавал болон сонгон судлах хичээлийн цагийн харьцааг суралцагч ажил мэргэжлийн чиг баримжaa олж авах, гүнзгийрүүлэн судлах, ур чадвар эзэмших үйл явцыг тооцон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага анги бүрээр тогтооно.

3.3.Нийт судлах хичээлийн тоо X анgid 8-10, XI анgid 6-8 байх бол XII анgid сонгон судлах болон мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын хичээл, хичээлийн дараах үйл ажиллагаа байхаар тооцно.

3.4.Сургалтын төлөвлөгөөг энэ чиглэлийн 2.4-т заасан чиглэл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. Сургалтын төлөвлөгөөн дэх заавал судлах хичээлийн тоо, ногдох цаг анги ахих тусам буурах, сонгон судлах хичээлийн тоо, ногдох цаг анги ахих тусам нэмэгдэх зарчим баримтална.

3.5.Мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын жишиг хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага холбогдох мэргэжлийн холбоо, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагатай хамтран боловсруулж, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6.15-д заасан журмын дагуу дүгнэлт гаргаж, баталгаажуулна.

3.6.Мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтаас бусад сонгон судлах сургалтын хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, дээд боловсролын холбогдох сургалтын байгууллагатай хамтран боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

3.7. Сонгон судлах хөтөлбөр дараах шаардлага хангасан байна:

3.7.1. суралцагчийн эзэмших мэргэжил, сонирхол, эсхүл авьяас, ур чадвараа хөгжүүлэх, өөрийн давуу байдалд тохирсон хичээл сонгож тодорхой чиглэлээр мэргэших боломж олгосон, мэргэших чиглэл, судлагдахууны агуулгаас хамаарсан хувилбартай байх;

3.7.2. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байрны шаардлага, ажил мэргэжлийн стандартад нийцсэн агуулгатай, сургалтын хөтөлбөрт тохируулга хийх боломжтой байх;

3.7.3. онол, дадлага, үйлдвэрлэлийн сургалт хосолсон агуулга, арга зүйн шийдэлтэй байх;

3.7.4. танхим, цахим, эдгээрийн хосолсон сургалтаар хэрэгжүүлэх боломжтой байх;

3.7.5. төсөлд суурилсан сургалтын үйл ажиллагааг тусгасан;

3.7.6. сонгон судлах болон мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын хичээлийг багц цагаар хэмжих, дараагийн түвшний сургалтад багц цагаа тооцуулах, хөрвүүлэх, дүйцүүлэх боломжтой байх.

3.8. Сонгон судлах хөтөлбөр нь их сургууль, коллежитой хамтарсан, эсхүл их сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн суурь хичээл байж болно.

3.9. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий боловсролын (IB Diploma, Cambridge A/AS гэх мэт) сургалтын хөтөлбөрөөс сонгон судлах боломжийг суралцагчдад олгож болно. Энэ тохиолдолд олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг орон нутаг, эсхүл эцэг, эх, асран хамгаалагч бүрэн хариуцах, энэ сургалтаар сонгон судлах хичээлийг тооцно.

#### **Дөрөв. Мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт**

4.1. Их сургууль, коллежийн харьяа ахлах сургуулиас бусад төрөлжсөн ахлах сургууль нь суралцагчдад энэ чиглэлийн 2.4-т заасан технологи, хөдөө аж ахуй, эрүүл мэнд-сувилахуй, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ гэсэн чиглэлээс сонгон мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт зохион байгуулна.

**Тайлбар:** Энэ чиглэлийн 4.1-т заасан “мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт” нь Мэргэжлийн болон техникийн боловсролын тухай хуулийн 6.4-т заасан сургалтын агуулгаар тодорхойлогдоно.

4.2. Мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт нь тодорхой мэргэжил, хөдөлмөр эрхлэх ур чадвар, чадамж эзэмшихэд чиглэх бөгөөд суралцагчийн эзэмшсэн чадамжийг үнэлж, төгсөгчдөд холбогдох хууль тогтоомжийг баримтлан чадамжийн гэрчилгээ олгоно.

4.3. Мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтыг тухайн сургууль нь тодорхой шаардлага хангасан бол бие дааж, эсхүл орон нутаг дахь мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшлах хүний нөөц, сургалтын хэрэглэгдэхүүн, дадлагын газрыг түшиглэн онол, дадлагын сургалт, дагалдан дадлага хийх хэлбэрээр хамтран зохион байгуулна.

4.3.1. мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтын дадлагын сургалтыг тухайн орон нутаг дахь аж ахуйн нэгж байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж болно.

4.4. Төрөлжсөн ахлах сургууль нь мэргэжлийн ур чадвар, чадамж эзэмшүүлэх чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, эсхүл гадаад улсын хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

4.5.Мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалт нь тухайн орон нутаг дахь мэргэжлийн боловсролын сургууль болон политехник коллежийн мэргэжилтэн бэлтгэж байгаа мэргэжлийн чиглэлтэй давхардалгүй байна.

4.6.Тухайн орон нутаг дахь мэргэжлийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээ бүрэн хангагдаагүй тохиолдолд энэ чиглэлийн 4.5 дахь заалтыг мөрдөхгүй.

**Тав.Төрөлжсөн ахлах сургуулийн сургалт,  
үйл ажиллагааны зохион байгуулалт**

5.1.Төрөлжсөн ахлах сургууль нь нэг ээлжтэй байх бөгөөд сургалтын үйл ажиллагаа бүтэн өдрийн зохион байгуулалттай байна.

5.2.Бүлэг дүүргэлт заавал судлах хичээлд 30-35, сонгон судлах хичээлд 15-25, дадлагын сургалтад 10-15 байна (орон нутгийн онцлогийг харгалзан бүлэг дүүргэлт уян хатан байх, сургууль дундын цахим сургалт зохион байгуулах г.м).

5.2.1.Сонгон судлах хичээл, мэргэжлийн эрх олгох/мэргэжлийн сургалтыг анги, бүлгээс үл хамааран холимог бүлгээр зохион байгуулж болно.

5.3.Суралцагч сонгон судлах хичээл/өөрийн мэргэших чиглэлээр хичээлийн жилд 3-аас доошгүй туршилт, лаборатори, судалгааны ажил, эсхүл төсөлт ажил бие даан, эсхүл багаар заавал гүйцэтгэх бөгөөд явц, үр дүнг улирлын болон хичээлийн жилийн төгсгөлд хамгаална.

5.4.Хичээлийн дараах үйл ажиллагаагаар суралцагч бусадтай хамтран суралцах, сурлагын хоцрогдол нөхөх, ажил мэргэжлийн зөвлөгөө авах, сайн дурын ажил хийх, нэмэлт сургалт болон дугуйлан секц, клубт хамруулах зэрэг үйл ажиллагаа зохион байгуулна.

5.5.Суралцагчдад туслах, дэмжих үйлчилгээ үзүүлэх нэгж ажиллана. Энэ нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.5.1.суралцагч суралцах төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

5.5.2.суралцагч бүрийн авьяас, сонирхол, ирээдүйд эзэмших мэргэжил, сонирхлын дагуу тохирох хичээл сонгох, ажил мэргэжлийн сонголт хийх, сайн дурын үйл ажиллагаа санаачлах, оролцоход туслах;

5.5.3.тухайн их сургууль, коллежид элсэх анкет бөглөхөд дэмжлэг үзүүлэх;

5.5.4.ажил мэргэжлийн ирээдүйн чиг хандлага, ирээдүйд шаардлагатай чадамж, ажил мэргэжлийн чиглэлийн мэдээллээр хангах;

5.5.5.цаашид сурах, мэргэших боломжийн талаарх мэдээлэл өгөх, туслах;

5.5.6.ажил олгогч, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсролын сургалтын байгууллагатай уулзалт, өдөрлөг зохион байгуулах, ажил мэргэжлийн бодит байдалтай танилцах, дадлага хийх, туршлага олж авахад туслах;

5.5.7.ажилд зуучлах, ажлын ярилцлагад бэлтгэхэд туслалцаа үзүүлэх;

5.5.8.ажлын байранд ажиллах бэлэн байдалд дэмжлэг үзүүлэх (зөвлөн чадвар /харилцаа, багаар ажиллах, шийдвэр гаргах, дасан зохицох гэх мэт/ хөгжүүлэх бэлэн);

5.5.9.суралцагчдын эрүүл мэндийг дэмжих, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх.

5.6.Төрөлжсөн ахлах сургууль нь хамран сургах тойргоос үл хамааран суралцагч элсүүлэх бөгөөд элсэлт зохион байгуулахад суралцагчийн суралцах чадамж, авьяас сонирхол, ирээдүйд эзэмших мэргэжил, ажиллах чиглэлээ төсөөлсөн байдлыг харгалзана.

## **Зургаа. Төрөлжсөн ахлах сургуульд тавих шаардлага**

6.1.Төрөлжсөн ахлах сургууль нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

6.1.1.сонгон судлах хөтөлбөр хэрэгжүүлэх чадамжтай багшлах хүний нөөцтэй байх;

6.1.2.сургалтын хөтөлбөрийн дагуу туршилт, судалгаа, дадлага, төсөлт ажил хийх багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хүртээмжтэй байх;

6.1.3.физик, хими, биологи, инженерчлэлийн лабораторитой байх;

6.1.4.нэг суралцагч нэг компьютер эзэмших боломжтой мэдээллийн технологийн танхимтай байх;

6.1.5.цахим сургалт зохион байгуулах тоноглогдсон танхим (цахим хэрэглэгдэхүүн VR, AR, виртуал, симуляц орчин)-тай байх;

6.1.6.хөгжим, театр, дүрслэх урлаг, медиа урлагийн зориулалтын орчинтой байх (урлаг, соёлын);

6.1.7.спорт заалтай байх;

6.1.8.хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан хүртээмжтэй орчин бүрдсэн байх (налуу зам, брайл зам, тэргэнцэртэй иргэн зорчих зам, шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн тусгай тоноглол бүхий өрөө, цахилгаан шат, өргүүрт тавцан гэх мэт);

6.1.9.номын сан, хэвлэмэл болон цахим мэдээллийн сантай, олон улсын мэдээллийн сүлжээнд холбогдсон байх;

6.1.10.дотуур байртай байх;

6.1.11.үдийн хоолоор үйлчлэх боломжтой байх.

--000--